



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/262

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8 дэх хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.17 дахь заалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Олон улсын сайн дурын урологийн эмч нарын нийгэмлэг хооронд 2013 оны 08 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 2 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Нарантуяа/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД

А.ЦОГЦЭЦЭГ



080870



 Эрүүл мэндийн сайдын
 2017 оны 07 сарын 26-өдрийн
 дугаар тушаалын хавсралт

**МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭГЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
 ЗӨВШӨӨРӨЛЖИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА**

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сертификаар	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрөл лийн терел	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Дэвид Ричард Вандэрстен Vandersteen David Richard	Америкийн Нэгдсэн Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001756	Беөрний мэс засал судлал /хүүхдийн/ 7 хоног	Эмчлэх	2017-09-23 2017-09-30 7 хоног
2.	Куратани Норифуми Kuratani Norifumi	Япон Улс	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001757	Мэдээгүйжүүлэг судлал	Эмчлэх	2017-09-23 2017-09-30 7 хоног